

ХҮННҮ НАРЫН ХҮРЭЛ ЗЭВСГИЙН ТУХАЙ**А. Дамдинсүрэн**

Хөдөлмөрийн зэвсэг бол К. Марксын зааснаар, хүний ажлын хүчний хөгжлийн хэмжүүр төдийгүй, тэрхүү хөдөлмөр явагдаж байгаа нийгмийн харилцааны үндэс суурь болно. «Арилж үгүй болсон амьтдын дүрсийн зохион байгуулалтыг судлахад ясны үлдэгдлийн зохион байгуулалт хэрэгтэйн адил, устаж үгүй болсон нийгэм-эдийн засгийн хэлбэршлийг хөдөлмөрийн хэрэгслийн үлдэгдэл мөн төчнөөн чухал болно»¹.

Үйлдвэрлэлийн техникийн эргэлт эрт орой хэдийд ч нийгмийн амьдралд үндсэн өөрчлөлтөд хүргэдгийг түүх харуулж байна. Чулуун зэвсгээс хүрэл зэвсэгт шилжсэн нь хүй нэгдлийн байгууллыг эвдэж, ангит нийгмийг үүсгэхэд хүргэв. Хүй нэгдлийн нийгэмд үйлдвэрлэх хүч дорой хөгжилтэй байсан учир бүхий л бүтээж бий болгосон зүйлээ үлдээлгүй хэрэглэдэг байжээ. Ганц нэг хүмүүс хувьдаа өмчилж болохоор ямар нэгэн илүүдэл бүтээгдэхүүн байсангүй.

Хөдөлмөрийн багаж зэвсгийг хүрлээр, ялангуяа төмрөөр хийх болсон нь хөдөлмөрийн бүтээмжийг ихэд дээшлүүллээ. Адгуусан амьтдын хүчээр хөдлөх төмөр хошуутай анжис, төмөр сүх, хүрд хэрэглэсэн нь газар тариалан болон бусад аж ахуйг хөгжүүлэх өргөн боломж нээсэн юм.

Төмөрлөг зэвсэг гарч ирсэн нь гар үйлдвэрлэлийн болон бусад олон салаа салбарын ажлын бүтээмжийг урагш ахиулав. Үүнтэй холбогдуулж үзэхэд Монгол нутагт хүрлийн үед хүрэл эдлэл боловсруулах ажил их эрчимтэй явагдаж байжээ. Хүрэл олзворлон боловсруулж байсан ул мөр Монгол нутгийн өнцөг буланд олон тохиолдож байгаагийн дээр янз бүрийн эдлэл болон сумны хүрэл зэв нэн элбэг олддог билээ. Монгол нутагт хүрлийн үйлдвэрлэл явуулж байсан жинхэнэ эзэд нь хэн бэ? гэдгийг судлаачид нарийн нягтлан тогтоогоогүй байна. Хүрлийн үед Монгол нутагт хүрлийн үйлдвэрлэл явуулж байсан эзэд нь Хүннү болон хүннүгийн өвөг дээдэс мөн билээ. Гэхдээ Монгол нутагт хүрлийн үйлдвэрлэл явуулж байсан эздийг олж тогтоохдоо бүдүүвч таамаглалаар биш, харин тодорхой бодит баримтанд тулгуурлах ёстой. Үүнд:

Монгол орон хүрэл зэвсгийн үеийг хүн төрөлхтөний нэгэн адил бүрэн хэмжээгээр үзэж өнгөрүүлсэн байна. Монголын уудам нутгийн олон газар эрт цагт зэс ашиглан боловсруулж байсан ул мөр олдсоор

¹ К. Маркс. Капитал I боть, 187-р тал.

байна. Энэ талаар зарим баримтыг дурдвал: Дорнод аймгийн Халх гол сум, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум, Онгон, Хонгор, Дарьганга сумд, Дорноговь аймгийн Эрдэнэ (Өргөн-цэцэрлэг), Мандах, Даланжаргалан сумд, Өмнөговь аймгийн Манлай, Номгон сумд, Өвөрхангай аймгийн Гучин ус, Говь-Алтай аймгийн Бигэр, Төв аймгийн Говь-Сүмбэр сумдын нутгаас зэсийн хүдэр малтаж байсан орд (уурхайн) ором, эрт цагт зэс, хүрэл хайлж байсан нутаг бууц, зарим газраас зуухны улбаа олджээ.² Өмнөговь аймгийн Манлай сумын говийн төхөм дахь зэсийн хүдэр хайлуулж байсан газрыг шинжлэн судалж үзэхэд уг зэсийн хүдрийг тэндээс зүүн хойш 30—40 км-т орших Хар Аргалант уулнаас малтан авч байсан ором байна.³ Эдгээр олдворын хамгийн эртнийх нь МЭӨ II мянган жилийн үед холбогдоно гэж археологчид шинжээчид магадалжээ.⁴

Манай нутгаас олдсон хүрэл эдлэлийг байлдааны, аж ахуйн, урлагийн эдлэл гэж үндсэнд нь гурав хувааж болох юм. Хүрэл зэвсгийн дотор харвуулын сумны шилбэтэй буюу онгитой олон хэлбэрийн том жижиг зэвүүд, мөн байлдааны ба агнуурын зориулалттай хутганууд, сүх, жад зэрэг зүйлс байжээ. Манай эриний өмнөх II мянган жилийн үед Монгол нутагт анхны төмөрлөг болох хүрлийг ийнхүү эхлэн хэрэглэх болж, нэгэн мянга гаруй жилийн турш хүрэл хөдөлмөрийн багаж зэвсэг хийх гол хэрэглэгдэхүүн болж байжээ.⁵ ЗХУ-ын археологч профессор С. Д. Киселев «Тэр үеийн Хүннүгийн үйлдвэрлэлийн багаж нь хүрэл эдлэл байлаа. МЭӨ нэг мянганы дундуур үед Хүннүд хүрлийн үйлдвэр хүчтэй хөгжсөн юм»⁶ гэж бичсэн байдаг. Үүнийг хятадын эртний сурвалж бичиг давхар баталж байна. Хан улсын сударт: «Хан улсын жанжин Дэн Цзунь гэгч Хүннүгээс 2--3 мянган ширхэг сэлэм, хутгыг олзлон авчээ. Тэдгээр нь цөм хүннүгийн хүрэл сэлэмнүүд байв гэсэн байдаг.⁷

Монголд хүрлийн үйлдвэр их хөгжиж байсан нь илэрхий байна. Нэлээд хөгжсөн хүрлийн үеийг Улсын төв ба орон нутгийг судлах музейнүүдэд хадгалагдаж байгаа гойд сайхан хийцтэй хүрэл хэрэглэгдэхүүн Өмнөговь аймгийн Булган сумын нутаг Төгрөг-ширээт зэрэг газраас олсон хүрэл эдлэл цутгах чулуун хэвээр мэдэж⁸ болно. Түүний дундаас хамгийн олон нь хүрэл хутга, сумны хүрэл зэв (хушуу) болно. Монгол нутгаас олдсон хүрэл хутгын зүйлийг: а) Бөгтөр мөртэй, тэгш үзүүртэй; б) бөгтөр мөртэй, зэтэн үзүүртэй; в) шулуун мөр (хажуу) үзүүртэй гэж хуваана. Хутганы ишний оройд нэг, хоёр гогцоо буюу амьтны дүрс, цөн мэт чимэглэл хийж, ишний хоёр хажууг хэлхээтэй эрхэн хээ, гурвалжин, дөрвөлжин хээ, амьтны дүрсээр чимсэн байдаг. Жишээ нь: Сүхбаатар аймгийн орон нутгийг судлах

² В. Е. Ларичив, А. П. Окладников. Исследователь древней культуры Азии. Иркутск. 1958, с. 3. БНМАУ-ын түүх, тэргүүн боть. УБ., 65-р тал. Д. Наваан. Дорнод Монголын хүрлийн үе. УБ., 1975. 115-118-р тал.

³ Археологийн судлал. УБ., 1982. 49-р тал.

⁴ Мөн тэнд. 49-р тал.

⁵ БНМАУ-ын түүх, тэргүүн боть. УБ., 1966 он. 66—73. «Археологийн судлал» УБ. 1982, 49-р тал.

⁶ Киселев. С. В. Дреня история Окной Сибири. М. 1951 г.

⁷ Чжоу Вэй. Хятадын цэргийн зэвсгийн түүхийн материал. 1957. 209-210-р тал.

⁸ БНМАУ-ын түүх. УБ., 1966. 65-р тал.

музейд байгаа хэдэн хутга юм. Нэг хутганы дээр зэллэн ниссэн шувуудын дүрс, мөн цуварсан адууны зурагтай байна.⁹ Өмнөговь аймгийн баруун өмнөд хэсгээс олдсон ишнийхээ орой дээр тэх (янгир)-ийн толгойтой байлдааны том хутга,¹⁰ мөн Завхан аймгаас олдсон ишнийхээ үзүүрт тэхийн толгой дүрстэй¹¹ хүрэл хутга зэрэг нь гойд сонин байв.

Хүрэл зэвсгүүдийн дотор олон тоогоор бас нэг зүйл нь харвуулын сумны зэв болно. Хүрэл зэв онгит, шилбэт, дуут гэх мэт олон янз байжээ. Тэдгээрийн дотроос нэлээд түрүү үеийнх нь МЭӨ VII--VI зууны үед холбогдох хоёр дэлбээтэй онги бүхий зэвүүд бөгөөд гурван дэлбээт шилбэт зэвүүдийг МЭӨ VI--V зууны үед хийх болжээ. Гурван дэлбээт ба цагирган онгит зэвүүд Монголын умард өмнөд хөрш оронд бараг байдаггүйг үзэхэд тэдгээр зэв нь Монголын хүрэл зэвсгийн үед гарсан өвөрмөц зүйл бололтой.¹² Одоогийн БНМАУ-ын бүх нутагт (түүнчлэн Дорнод Монголд) дэлгэрсэн бөгтөр мөртэй хүрэл хутгууд Цагаан хэрмээс хойших газар нутаг, Өмнөд Сибирь, Байгаль нуурын өмнөд хэсэгт үйлдвэрлэгдсэн зүйлс мөн.¹³

Он цагийн хувьд Монгол орноос олдож байгаа бөгтөр мөртэй хутгууд Цагаан хэрмээс хойших нутаг Ордос, Ар, Өвөр Монголын бусад нутаг, Сибирийн Карасукийн үеийн материалтай ижил, МЭӨ XIII-XV зуунд голчлон холбогдох төлөвтэй бөгөөд тэр үед Төв Азид хүрлээр элдэв эд эдлэл багаж зэвсэг үйлдвэрлэх явдал өрнөн хөгжиж байв.¹⁴ Гурван хянгат зэв бол Төв Ази, Монгол нутгийн хэлбэр хийц гэж зарим эрдэмтэд үзэж байгаатай санал нийлж байгаагаа дээр өгүүлсэн бөгөөд энд нэмж хэлэхэд гурван хянгат (хэдэн янз) зэв бол навчин хэлбэрт зэвээс сайжран хөгжсөн нь агаар зүсэн нисэх талаар сайн, ямар нэгэн ан амьтныг шархдуулахдаа хөнөөл ихтэй, техникийн бүтцээр шат ахисан зэвсэг байлаа.¹⁵

Хүрлийн дараа төмөр залгахад зэвсгийн энэ хэлбэрийг улам сайжруулан хоёр давхар гурван хянгат (бүгд 6 хянгат) төмөр зэв хүннүгийн үед хийж байсан нь археологийн материал дотор буй.¹⁶ Монгол нутгаас олдсон хүрэл зэвийн дотроос хамгийн урт нь онгит навчин зэв 9 см урт байна.¹⁷ Үүнээс жижгэвтэр 4--6 см урт онгит навчин зэв нь МЭӨ VII--V зуунд холбогдоно гэж үзжээ.¹⁸ Иймд БНМАУ, ЗХУ-ын Шинжлэх Ухааны Академиудын хамтран явуулсан археологийн шинжилгээний ажлыг БНМАУ-ын нутагт сүүлийн 40 гаруй жилийн турш явуулсан судалгаа шинжилгээний ажлын үр дүнд хүрэл зэвсгийн үйлдвэрлэл явуулж байсан ор мөр болон хүрэл зэвсэг их олдож байгаагаас гадна манай орны төв ба орон нутгийг судлах аймаг, хотын музейнүүдэд хүрэл зэвсэг их хэмжээгээр хадгалагдаж байна.

⁹ Н. Сэр-Оджав. Хоёр хүрэл хутга. ШУ сэтгүүл. № 6. 1960.

¹⁰ Даланзадгад хотын музейд бий.

¹¹ Улсын төр музейн үзмэрт бий.

¹² БНМАУ-ын түүх, тэргүүн боть. УБ., 1966, 66-р тал.

¹³ Д. Наваан. Дорнод Монголын хүрлийн үе. УБ. 1975, 88-р тал.

¹⁴ Мөн тэнд

¹⁵ В. В. Волкон. Бронзовые наконечники стрел из музеев, МНР. «Монгольский археологический сборник» 1962, 26-р тал.

¹⁶ Д. Наваан. Дорнод Монголын хүрлийн үе. УБ., 1975, 97-р тал.

¹⁷ Мөн тэнд. 74-р тал.

¹⁸ Н. Сэр-Оджав. Хэнтий аймгийн орон нутгийг судлах музейд байгаа хүрлүүд. «Шинжлэх Ухааны Академийн мэдээ» 1969, № 1. 78-р тал.

Эдгээр зэвсгийн талаар гадаад, дотоодын эрдэмтэд тайлбар, тодорхойлолтуудыг хийж хэвлүүлсээр байна.

Монгол нутагт хүрэл зэвсгийн их хэмжээний үйлдвэрлэлийг явуулж байсан Хүннү нарын тухай чухам хэдий үеэс эхлэн түүхэнд нэр нь гарах болсон тухайг хүннүгийн судлалын мэргэжилтэн-эрдэмтдийн бичсэн бүтээлүүдэд нэг дор бөөн биш боловч хэсэгчилсэн судалгааны мэдээнүүд нийтлэгдсээр иржээ.

Хятадын түүхч Ван Говэй хүннүгийн түүхэнд холбогдох Хятад сурвалж бичгийн дотор байгаа нэрсийг нарийвчлан судлаад хүннүгийн хамгийн эртний аймаг нь МЭӨ XI—III зууны эхэнд хятадын Чжоу улсын үед «Гуны» бас «Сюньюй», «Сяньюнь» гэдэг нэртэй байсан, тэдгээр нь цөм нэгэн нэр мөн болохыг нотолжээ.¹⁹

МЭӨ XI зууны үед холбогдох хүрэл савны бүрэн бус бичээсэнд дурдсанчлан хятадууд Гуйфаныг (хүннүг) довтлоод үхэр, хонь, тэрэг олзлон авч байжээ.²⁰ Тэр үед Гуйфан нар нь тэрэг хэрэглэж, мал малладаг нүүдэлчин аймаг байсныг харуулж байна. Тэдгээр аймаг нь Хүннү нар юм уу эсвэл хүннүтэй нэгэн гаралтай салбар аймаг байв.

Сяньюнь аймаг МЭӨ 823 онд хятадыг довтлож байсан тухай хятад сурвалж бичигт анх нэр дурдагджээ.²¹ Сяньюнь нар хүннү шиг тэнгэрт тахилга үйлдэхдээ морь алан тангараглаж байсныг Голландын судлаач Я. Прушек зохиолдоо дурдаад, тэднийг БНМАУ-ын нутагт байсан байх гэж үзжээ.²² Судлаач Р. Гресе, Х. Кордьер, П. Пеллио, Ф. Хирт, К. Сиратори, О. Прицак, Мэн Вэньтянь, В. Эбэрхард нар сяньюнь, сюньюй нарыг Хүннү мөн гэж үзэцгээжээ.²³ Б. Карлгрэн сяньюний удам нь Хүннү мөн бөгөөд хүрлийн үед ордос нутгийн анхны эзэн нь сяньюнь нар байв гэж үзжээ.²⁴

Хятадын түүхч Ли Сунь «Умард хилийг сүрдүүлж байсан хүчирхэг дайсан» гэсэн өгүүлэлдээ: «МЭӨ XI—III зуун хүртлэх хугацаанд Чжоу улс, Цинь улс хүртэл үед хятад үндэстнүүд тасралтгүй умардын нүүдэлчин Хүннүгийн аюулд өртөж байсан ба байлдаанч улсын үед Янь, Чжоу зэрэг улсууд Цагаан хэрмийг барьж Хүннүгийн түрэмгийллийг халхалж байсан юм»²⁵ гэж бичсэн байдаг. Үүнээс гадна Чжао улсын ван У Лин МЭӨ 325—299 онд Ордос орчмын Хүннүгийн нутгийг эзлэн авч Чжү-Юан гэдэг газарт Жун гэдэг хятад суурин байгуулан хориглолт²⁶ бэхлэлт хийж байсныг нь Хүннү нар мэдээд хятадын эзлэн авсан газрыг авах гэж хятадтай байлдаад ялж өөрийн газар нутгаа эргүүлэн авч байжээ. Эдгээр түүхийн баримтаас гадна археологийн материал руу орж үзвэл: БНМАУ-ын нутгаас олдож байгаа дөрвөлжин булшны он цагийн түрүү үе нь МЭӨ VIII—V зуун, хожуу үе нь МЭӨ V—III зуунд хамааруулсан эрдэмтдийн саналыг

¹⁹ Ван Говэй. Зохиолын 4-р боть, Бээжин, 1959, 584, 590, 592-р тал.

²⁰ Мөн зохиол. 586—587-р тал.

²¹ Jaroslav Prusek. Chinese statelets and northern barbarians 1400-300 B. C. Dordrecht-Holland. 1971. p. 119

²² Мөн зохиол. 11, 21-р тал.

²³ Хатторийн зохиол 4-р боть. W. Edethard. Kultur und sielund der Ran dvolker China. Supplement au T'uong paos vol. XXXVI Leiden. 1942, p. 384.

²⁴ Jaroslav Prusek. Chinese statelets ...p. 106

²⁵ Ли Сунь «Жэньминь чкунго» 1963 он. Бээжин, № 8, 77-р тал.

²⁶ Чкунго гудай ши. Бээжин. 1977, 278-р тал.

Н.Сэр-Оджав зөв гэж үзжээ.²⁷ Д. Наваан Дорнод Монголд малтсан 46 булшнаас гарсан малын ясанд адууных 42, үхрийнх 12, бог малынх 9, тэмээнийх 6 байсны үндсэн дээр дөрвөлжин булшны эзэд таван хошуу малтай нүүдэлчид байсныг²⁸ нотолжээ. БНМАУ болон Буриадад Ц. Доржсүрэн, И.Эрдели, Д.Наваан, Н.Сэр-Оджав, А.В.Давыдова нарын малтсан дөрвөлжин булшнаас олдсон материалд түшиглэж В. В. Волков бичсэн нь: «Дөрвөлжин булшны соёл нь Умард Хүннүгийн соёл бүрдэх нэг эх булаг болсон нь тод байна»²⁹ гэжээ. Н.Сэр-Оджав, Өвөрхангай аймгийн Хужиртын Шунхлайн булшны гурван дэлбээтэй онгит ясан зэв Иволгийн сууриныхтай адилавар, түүнчлэн мөн дөрвөлжин булшны ба Хүннүгийн ваар ойр төсөөтэй гэж үзэж байна.³⁰ Д. Наваан хүннүгийн том язгууртны булшны байдал нь дөрвөлжин булшны барилгын арга хэлбэрийн шууд үргэлжлэл гэж бичжээ.³¹ В. В. Волков дөрвөлжин булшны ба хүннүгийн оршуулгын зан үйлд ерөнхий нийтлэг шинж багагүй байгааг дурджээ.³² Л. Н. Гумилев дөрвөлжин булшны соёл бол үнэн хэрэг дээрээ хүннүгийн биеэ даасан соёлын түрүүчийн шат мөн гэжээ.³³

Эдгээр судалгаанаас үзэхэд хүрлийн үед холбогдох археологийн янз бүрийн олдворууд болон дөрвөлжин булшууд нь хүннүд гарцаагүй хамаарагдаж байна. Үүнээс гадна судлаачид дөрвөлжин булшнаас гарсан хүний ясанд антропологийн талаар нарийн судалгаануудыг хийж иржээ. Энэ тухай ЗХУ-ын нэрт археологч доктор В. В. Волков антропологчдын судалгааны материалыг үндэслэн бичсэн нь: «Өвөр байгалийн дөрвөлжин булшны хүмүүсийн үлдэгдлийг судалсан антропологчид үзэхдээ тэдгээр нь том монголжуу арьстны умард мөчирт хамаарагдах ерийн монголжуу хүмүүс байсныг тогтоосон. БНМАУ-ын ихэнх хэсэг дээр хүрлийн сүүл үед одоо энэ орны үндсэн хүн амын маягийн хүмүүс байсан³⁴ байна» гэжээ. А. П. Окладниковын судалгаагаар, Өвөр Байгалийн хүрлийн үеийн хадны шувуун дүрстэй зураг нь ольхоны Буриадын ноосон оймсныхтой ер бусын ижил байгаа явдал монголын ард түмний соёл, урлаг нь МЭӨ 1 мянганы үеийн бусад зарим аймгийн урлагтай холбоотойг харуулж байна.³⁵

Дөрвөлжин булш, хүннүгийн булш зэргээс гарсан гавлын ясыг харьцуулан судлаж үзсэн Н. Н. Мамонова бичсэн нь: «Өвөр Байгалийн өмнөд хэсэг, Умард Монголын палеоантропологийн шинэ материалыг задлан шинжлэхэд Черемухомын ам, Сүүж, Дархан хотын булшинд байсан гавлын яснууд нь арьстны талаар том монголжуу арьст-

27 Н. Сэр-Оджав. Монголын эртний түүх. УБ ., 1977 он. 48—49-р тал.

28 Д. Наваан. Дорнод Монголын хүрлийн үе. УБ ., 1975 он. 106-р тал.

29 В. В. Волков. Бронзовый и ранний железный век Северной Монголии. «Археологийн судлал». т. V. ф 1, УБ ., 1967 он. 45-р тал:

30 Н. Сэр-Оджав. Монголын эртний түүх. УБ ., 1977 он. 47--48-р тал

31 Д. Наваан. Дорнод Монголын хүрлийн үе. УБ ., 1975, 37-р тал.

32 В. В. Волков. Бронзовый и ранний железный век Северной Монголии. «Археологийн судлал» т. V, № 1, УБ, 1967, 102-р тал.

33 Л. Н. Гумилев. Хунну. М., 1960, с. 46.

34 В. В. Волков. Бронзовый и рапий железный век Северной Монголии «Археологийн судлал» Т., Ф. 1. УБ ., 1967. 102-р тал.

35 А. П. Окладников, «История и культура Бурятин. Улан-Үдэ. 1976. с. 196-197

ны палеосибирийн маягт багтана гэж тогтоож болохоор байна»³⁶ гэжээ. Унгарын эрдэмтэн Т. Тот бичсэн нь: Ноён уулын Хужиртын булшны эрэгтэй хүний том гарал нь том монголжуу арьстны палеосибирийн маягт багтаж байна.³⁷ Иволгын суурины хүн ам нь том монголжуу арьстны Сибирийн маягт хамрагдаж байна.³⁸ «Ингээд хүннү нарын үс өнгөөрөө барахгүй, мөн хэлбэрээрээ фин-угорынхоос ч, славян ард түмнийхээс ч эрс ялгаатай монгол арьстны ерийн үс байна. Ноён уулын булшнаас гарсан үс скифийн үеийн Алтайн хүнийхээс гоц ялгаатай байсан нь сонирхолтой»³⁹ гэж зөвлөлтийн судлаач С. И. Руденео бичсэн байна. Г. Ф. Дебецийн судалгаагаар үзэхэд: «Антропологийн маяг МЭӨ 1 мянган жилийн туршид өөрчлөгдсөнгүй. Хүннү нарт зүй ёсоор хамааруулдаг палеосибирийн онцлог маяг чухам энэ үед бүрэлджээ»⁴⁰ гэж бичжээ. Дээр дурдсан энэ баримт материалд тулгуурлан эцэст нь товч дүгнэхэд:

1. Монгол нутагт байсан хүрэл зэвсгийн үеийн энэ олон үйлдвэрлэлийн ор мөр одоо хүртэл олдсоор байгаа нь Монгол нутагт хүрлийн үйлдвэрлэл МЭӨ II мянганы үед биш, харин бодит байдлаас үзвэл МЭӨ IV-III мянган жилийн үеэс эхлэн анх суурь нь тавигдсан болох нь эргэлзээгүй. Зарим судлаач-шинжээчид Монгол нутагт МЭӨ II мянган жилд холбогдоно гэж үздэг нь хүрлийн үйлдвэрлэл нэлээд хөгжсөн үеийн баримтанд түшиглэсэн байх;

2. Монгол нутгаас олдож байгаа хүрэл эдлэлийн хийц, чимэглэлийн өвөрмөц байдал зэрэг нь нүүдэлчид малчдын амьдралыг дүрслэн харуулсан байдаг нь гаднын ямар ч нөлөөгүй цэвэр нүүдэлчдийн хөдөлмөрийн бүтээгдэхүүн мөн.

3. Дөрвөлжин булшны түрүү үе нь МЭӨ VIII-V гэж байгаа нь дэндүү наана мэт байна. Мэдээжээр дөрвөлжин булш нь Хүннүгийн өвөг дээдсийн үеийн зүйл болох бөгөөд барагцаалахад тэдгээр булшны он цаг нь хамгийн наад зах нь МЭӨ XII—VIII зууны үеэс наашгүй эртний зүйл болох нь дээр дурдсан баримтуудаас мэдэгдэж байна.

4. Хүннү нар нь МЭӨ 2500 жилийн үед ч энэ Монгол нутагт оршин амьдарч байсан нь маргаангүй билээ. МЭӨ XI зууны үед хятадууд Хүннүгийн аюулд өртөж байсан учраас Цагаан хэрмийг МЭӨ V—IV зууны үеэс эхлэн барьж Хүннүгийн аюулаас хамгаалав гэж хятадын түүхчид удаа дараалан бичсээр байна. Энэ нь чухам юуг нотолж байна вэ гэвэл нүүдэлчид тухайлбал Хүннү нар (Монголын өвөг дээдэс) нь хятадад эзлэгдэж байгаагүй, харин хятадтай аль эртнээс эхлэн эрх тэгш зэрэгцэн оршиж байсны нотолгоо мөн. Нөгөө талаар МЭӨ XI зууны үеэс эхлэн Хүннү нар хятадын заналт дайсан нь болж байсан бол, Хятад нь бас Хүннүгийн нэн аюултай дайсан байсан гэдгийг дээрх баримт харуулж байна.

5. Хүрлийн үед Монгол нутагт хүрлийн үйлдвэрлэлийг гардан явуулж байсан жинхэнэ эзэд нь Хүннү нар гарцаагүй мөн гэдэг дүгнэлтэд хүргэж байна.

³⁶ Н. Н. Мамонова. К антропологии гуннов Забайкалья «Расогенетические процессы и этнической истории», М., 1974, с.210—228,

³⁷ Т. Toth. Palaeoanthropological finds from the valley of Hidjirte (Noin Ula, Mongolia) "Acta Archaeologica Academiae Scientiarum Hungaricae" p. 251.

³⁸ А. V. Davydova. The wolga gorodische. Amonument of the Hsiungnu culture in the trans-baikal region, "AA", t, 20 1968. Budapest . p. 245

³⁹ С. И. Руденео. Культура Хуннов и Ноинулинские курганы. М--Л. 1962 (III)

⁴⁰ Л. Н. Гумилев. Хунну. М., 1960. С. 121.

О БРОНЗОВОМ ОРУДИИ ГУННОВ

(Р е з ю м е)

В данной статье автор попытался раскрыть начальную стадию производства бронзовых орудий и их обладателей.

Многочисленные следы производства бронзовых орудий, обнаруживающиеся по сию времени археологами и исследователями на территории Монголии, позволили автору прийти к выводу, что основа производства бронзового орудия заложена не во II тысячелетии до н. э., а в IV--III тысячелетиях до н.э.

Своеобразие украшений и производства бронзовых изделий, найденных на территории Монголии, изображает жизнь кочевых народов и является результатом их труда без внешнего влияния.

Раннюю эпоху плиточных могил Монголии автор считает не VIII—V вв. до н.э. а XIII—VIII вв. до нашей эры. Следовательно, плиточные могилы, безусловно, относятся к изделиям предков гуннов.

Опасаясь от нападений кочевников-гуннов, китайцы начали строительство Великой Китайской стены еще в V--IV вв. до н. э., о чем не однократно писались китайскими историками. Этот факт является доказательством того, что с давних времен гунны-предки монголов, как самостоятельные народы, имевшие свой государственные формирования, успешно соперничали с китайцами. С другой стороны этот факт неопровержимо доказывает, что с начала XI в. до н.э. гунны являлись потенциальным врагом Китая, а в свою очередь китайцы являлись таким же врагом для гуннов.

В заключении автор статьи подчеркивает, что обладателями бронзовых орудий на территории Монголии являлись именно гунны.